



БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ИНТЕРНЭТ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан¹)

ХИЙМЭЛ ОЮУН (AI) АШИГЛАН АЛИВАА ЭТГЭЭДИЙН ДУУ ХООЛОЙГ, ТҮҮНИЙ ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР ХУУРАМЧААР ДУУРАЙЛГАН БҮТЭЭХИЙГ ХОРИГЛОНО

САНАМЖ: Энэхүү хураангуй хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: (2023) 京0491 民初 12142

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч Янь Моужэнь нь мэргэжлийн дуу оруулагч, жүжигчин бөгөөд 2023 оны 5 дугаар сард өөрийн дуу хоолойг ашигласан контентууд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (аппликейшн)-ээр өргөнөөр тархсан болохыг олж мэджээ. Уг контентод ашигласан дуу хоолойг хиймэл оюун (Artificial Intelligence-AI)-д суурилан дуу бичлэг болгон хувиргах (text-to-speech) технологиор бүтээсэн бөгөөд нэхэмжлэгчийн дуу хоолойн өнгө, аяс, авиа зүйн онцлогийг дуурайлган ашигласан болох нь тогтоогдсон.

Тодруулбал, 2019 онд нэхэмжлэгч Янь Моужэнь нь С хэвлэл, мэдээллийн компанийн захиалгаар дуу хоолойн бичлэгт орсон бөгөөд тус бичлэгийн зохиогчийн эрх нь тухайн компанид харьяалагдаж байжээ. Гэвч тус компани нь программ хангамжийн компанитай “Өгөгдөл ашиглах эрхийн гэрээ” байгуулж, нэхэмжлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөл, гарын үсэггүйгээр түүний дуу хоолойг ашиглаж, хиймэл оюуны аргаар дуу бичлэг болгон хувиргаж, хөгжүүлсэн байна.

Ийнхүү хиймэл оюуны аргаар бүтээгдсэн дуу бичлэг бүхий контент нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өргөнөөр түгээгдэж, нийт 3.2 тэрбум хандалт авсан бөгөөд нэхэмжлэгч уг үйлдлийг өөрийн бие хүний салшгүй эрх зөрчигдсөн хэмээн үзэж, шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

<https://www.sdcourt.gov.cn/dyzy/resource/cms/article/372898/35781100/2025031108461659757.pdf>



Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ БНХАУ-ын Иргэний хуулийн 995², 1000³, 1019⁴, 1023⁵ дугаар зүйлүүдийг үндэслэл болгож, дараах дүгнэлтийг хийжээ. Үүнд:

1. **Нэгдүгээрт**, хиймэл оюуны аргаар бүтээгдсэн дуу бичлэг нь бие хүний салшгүй эрх (personality rights-voice rights)-д хамаарах эсэхийг тодорхойлоход тус улсын Иргэний хуулийн 1023 дугаар зүйл чухал ач холбогдолтой. Тус заалтад зааснаар бие хүний салшгүй эрхийг хамгаалах үндсэн шалгуур нь тухайн этгээдийн дуу хоолойг таних боломжтой эсэх явдал юм.
2. Шүүхээс хиймэл оюуны аргаар бүтээсэн дуу бичлэг нь нэхэмжлэгчийн дуу хоолойны өнгө, аяс, авиа зүйн хэв маягийг дуурайлган хийсэн, олон нийт тухайн этгээдийг шууд таних боломжтой гэж дүгнэсэн бөгөөд нэхэмжлэгчийн бие хүний салшгүй эрхээ хамгаалуулах эрхэд хамаарна гэж үзсэн.
3. **Хоёрдугаарт**, нэхэмжлэгчийн дуу хоолойг ашиглахад хууль ёсны зөвшөөрөл авсан эсэх тухайд, С хэвлэл, мэдээллийн компанид дуу бичлэгийн зохиогчийн эрх нь харьяалагдаж байсан хэдий ч нэхэмжлэгчийн дуу хоолойг ашиглаж, хиймэл оюуны аргаар дуу бичлэг болгон хувиргах эрхгүй байсан. Мөн өгөгдөл ашиглах гэрээ нь нэхэмжлэгчийн гарын үсэг бүхий зөвшөөрөлгүй байсан тул шүүх хариуцагч талуудыг хууль ёсны зөвшөөрөл аваагүй гэж дүгнэсэн.
4. **Гуравдугаарт**, хариуцагчийн үйлдэл нь нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн эсэх тухайд, шүүх С хэвлэл, мэдээллийн компани болон программ хангамжийн компани нь нэхэмжлэгчийн зөвшөөрөлгүйгээр түүний дуу хоолойг хиймэл оюуны технологиор боловсруулан ашигласан болохыг тогтоож, нэхэмжлэгчийн бие хүний салшгүй эрхийг зөрчсөн үйлдлийг таслан зогсоох хязгаарлалтын арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн байна. Харин нэхэмжлэгч эдийн засгийн болон сэтгэл санааны хохирол учирсан гэдгээ хангалттай нотолж чадаагүй тул уг хэсгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

---oOo---

² БНХАУ-ын Иргэний хуулийн 995 дугаар зүйл “Тухайн бие хүний салшгүй эрх (personality rights) зөрчигдсөн тохиолдолд зөрчил гаргасан этгээдээс энэ хуульд заасан эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, учирсан хохирлыг арилгуулах, нэр хүндийг сэргээх, уучлалт хүсэх зэрэг хариуцлага хүлээлгэхийг хүсэх эрхтэй. Эдгээр шаардлагад хуульд заасан аливаа хугацаа (жишээ: хөөн хэлэлцэх хугацаа) үйлчлэхгүй.”

³ БНХАУ-ын Иргэний хуулийн 1000 дугаар зүйл “Бие хүний салшгүй эрхийг зөрчсөн тохиолдолд хэргийг үйлдсэн этгээдэд ногдуулах хариуцлага нь тухайн этгээдийн үйлдлийн онцлог, арга барил, учирсан хохирлын хэмжээнд тохирсон байх ёстой.”

⁴ БНХАУ-ын Иргэний хуулийн 1019 дугаар зүйл “Аливаа этгээд бусдын бие хүний салшгүй эрхийг гутаан доромжлох, нэр төр, нийгмийн үнэлэмжид сөргөөр нөлөөлөх, бие махбод, гадаад дүр төрхийг өөрчлөх, эсхүл мэдээллийн технологийн хэрэгсэл ашиглан хуурамч дүр төрхийг бий болгох байдлаар бие хүний салшгүй эрхийг зөрчсөн үйлдэл гаргахыг хориглоно. Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн хүний зөвшөөрөлгүйгээр зөвхөн өөрт нь хамаарах дуу хоолой, дүрсийг бүтээх, ашиглах, олон нийтэд түгээхийг хориглоно.”

⁵ БНХАУ-ын Иргэний хуулийн 1023 дугаар зүйл “Бие хүний салшгүй эрхийг хамгаалахад хувь хүний дүрсний эрхийг хамгаалахтай адил журам үйлчилнэ.”